



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 8/223

Улаанбаатар хот

Өвс тэжээлийн нөөц
бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн малчин болон мал бүхий иргэдийн 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлж өвс татах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.

2.Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд шаардагдах төсвийг хавсралтаар баталж 5,800,000 (таван сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас, 700,000 (долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
17224 дугаар захирамжийн хавсралт



ӨВС ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Шаардагдах хэмжээ	Бүгд үнэ
1.	Өвс	Боодол	13,000	500	6,500,000
Нийт					6,500,000